

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-11

1. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн/	4-11
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
11 дүгээр сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 40 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Булгантуяа, Б.Жаргалан;

Томилолттой: Ш.Бямбасүрэн, А.Ундраа, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Очирбат;

Тасалсан: Ч.Анар, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, Б.Заяабал, С.Цэнгүүн.

Нэг. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Ч.Лодойсамбуу нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Р.Сэддорж: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж, тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 27 минут үргэлжилж, 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
16 цаг 40 минут.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Ренчиндоржийн Батболд гишүүн, Отгоншарын Батнайрамдал гишүүн, Пүрэвийн Батчимэг гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Мэндбаярын Мандхай гишүүн, Бадрахын Найдалаа гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн, Ренчинбямбын Сэддорж гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Болдын Уянга гишүүн, Мөнхчулууны Энхцэцэг гишүүн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53,1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 1. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Ухаа худаг ордын ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн асуудлаар Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025 оны 10 дугаар сарын 6-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 1.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Л.Оюун-Эрдэнэ: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан, төрийн нийтийн өмч мөн хэмээн тодорхой заасан байдаг билээ.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтоохоор

зохицуулсан бөгөөд гагцхүү Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн байгалийн баялаг, стратегийн ордуудыг захиран зарцуулах онцгой эрхтэй хэмээн хуульчилсан.

Тавантолгой чулуун нүүрсний ордын хайгуулыг БНМАУ 1940 оноос эхлэн хийж, 1990 он хүртэл 50 жилийн хугацаанд улсын төсвөөс санхүүжүүлсээр ирсэн бөгөөд тус ордын бүрэлдэхүүн хэсэг болох Ухаа худгийн хэсгийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлгүй шийдвэрлэсэн эсэх талд дүгнэлт гаргаж, баримт бичгүүдийг нотлон шинжилж, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний 1/4-ээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэж заасныг үндэслэн Улсын Их Хурлын нэр бүхий 33 гишүүн санаачлан энэхүү тогтоолын төслийг өргөн барьж, хэлэлцүүлж байна.

Хянан шалгах түр хорооноос Тавантолгой бүлэг ордод хамаарах тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалт Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, холбогдох баримт бичиг үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт шалгалт хийснээр стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн бүлэг ордтой холбогдуулж, олон нийтийн мэдэх эрх хангагдаж, иргэд Тавантолгой бүлэг ордыг хамрах тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалт, эдийн засгийн үр өгөөж, нөөцтэй холбогдуулж бодит мэдээлэлтэй болно хэмээн үзэж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 33 гишүүнээс санаачлан өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт сууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуугаар тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Эрхэм гишүүдээсээ бас хүлцэл өчье. Жаахан тийм эсрэг байр суурь илэрхийлэх болж байна.

Энэ үндсэн шалтгаан нь болохоороо ер нь бол Улсын Их Хурлын түвшинд уул уурхайн салбартай холбоотой маш их яриа яригддаг болсон. Тэгээд ер нь яг нухаад үзэхээр Засгийн газрын хийх ажил, эсвэл аль хэдийн ажлын хэсэг нь явж байгаа ажил нэг тиймэрхүү байдлаар энэ салбарын ойлголт нэлээн өөр байдлаар түгээд байгаа. Яг энэ Хянан шалгах түр хорооны төсөлтэй танилцахад бол 3 асуудлыг хөндөж байгаа.

1 дүгээр асуудал нь болохоороо ер нь Ухаа худаг гээд төслийн тусгай зөвшөөрөл нь хуулийн хүрээнд олгогдсон юм уу гэдгийг нь хянан шалгана гэсэн байгаа. Яг үүний дагуу аудитын дүгнэлт 2012 оны дүгнэлт байдаг гэсэн сургаар Эдийн засгийн байнгын хорооны ахлах референт, ахлах зөвлөх болон бусад ажлын албанаас бол хэд хэдэн удаа асуусан. Ерөөсөө мэдээлэл нь алга гэсэн байдлаар бол хариу ирсэн. Тэгтэл манай энэ Баяр Ерөнхий сайд асан гаргасан номыг нэлээн ингээд нухацтай харахад 52 дугаар баримтад 2012 оны 1 сарын 25-ны Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор яг энэ өнөөдрийн бид нар хэлэлцэж байгаа

Хянан шалгах түр хорооны эхний асуудлыг судал гээд гүйцэтгэлийн аудит хийх эрх нь олгогдоод, тэрний дагуу гүйцэтгэлийн аудит нь хийгээд , аудит нь зөвхөн энэ Энержи Ресурс компанитай холбоотой асуудал биш хажуугаар нь Оюутолгойн нөөцийн асуудлаас ингээд орчихсон ийм 2 бүлэг асуудлыг хэлэлцсэн дүгнэлт гарсан байгаа юм. Тэгээд дүгнэлт нь юу гэж гарсан гэхээрээ тусгай зөвшөөрөл энэ Тавантолгойн бүлэг ордын энэ Ухаа худаг, Энержи Ресурс компанийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөл нь 2006 онд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл Ашигт малтмалын тухай хууль шинэчилж найруулагдахаас өмнө олгогдсон байна буюу асуудал байхгүй байна гээд энэ 2012 онд дүгнэчихсэн ийм гүйцэтгэлийн аудитын тайлан байна.

2 дугаар асуулт нь болохоороо оффтейк гэрээнүүдийн талаар байгаа. Тэгэхээр саяхан бас Баярмаа гишүүн өөрийнхөө энэ асуулгатай холбоотой албан бичгийг танилцуулсан. Тэгээд би одоо уул уурхайн салбарыг ярьж ханасан гээд бас ингээд дэмжээгүй.

3 дугаар асуудал нь болохоор бас энэ Ухаа худаг төслийн мөнгөн дүнд шинжилгээ хийнэ гэсэн байдлаар бол орж ирж байна. Тэгээд би ойлгохдоо Улсын Их Хурал дээр түрүү чуулганы үеэр хаврын чуулганаар Мөнхтулга гишүүний ахалсан нэг ажлын хэсэг байгаа. Тэгэхээр ер нь бол миний үндсэн агуулга юу вэ гэхээрээ яг энэ Хянан шалгах түр хороог ийм 3 агуулгаар гаргах нь давхардсан эсвэл аль 2012 онд хийгдсэн ажлыг дахин хийх гэж байгаа агуулга биш үү гэдэг дээр саналаа хэлж байгаа юм. Тэгээд хэрвээ хариулт байвал бас хариулах байх.

Р.Сэддорж: Оюун-Эрдэнэ гишүүн хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Та бүхэн мэдэж байгаа бүх гишүүдэд тарааж өгсөн. Ийм Засгийн газраас ажлын хэсэг гаргаад ийм эмхэтгэлийг бүх гишүүдэд тарааж өгсөн. Тэгээд энэ болохоор бас энэ нөгөө маргаантай, олон нийтийн хувьд бас нэг тийм мэдэх эрх нь хангагдахтай холбоотой л ийм асуудал гэж бол үзэж байгаа. Тухайн үед бол Засгийн газрын тэмдэглэлээр энэ шийдвэр гарсан байдаг. Тэмдэглэл бол өөрөө эрх зүйн акт бас биш. Улсын Их Хурлаар орсон эсэх тухай ийм асуудал байдаг. Аудитын дүгнэлт байж болох ч гэсэн аудитын дүгнэлт бол өөрөө ордыг шийдэх тийм эрх бүхий субъект бол бас биш байдаг. Тийм учраас энэ асуудал дээр Уянгаа гишүүн ч гэсэн боломжтой бол өөрөө орчхоод, энд төлөөллийг нь хангаад олон талаас нь хэдүүлээ ярилцаад, тэгээд энэ олон нийтийн эргэлзээг тайлчих нь зүйтэй юм биш үү л гэж бодож байгаа юм. Ямар нэгэн байдлаар хувийн хэвшилтэй холбоотой, энэ ордтой холбоотой маргаан гэхээс илүүтэйгээр ер нь Улсын Их Хурлын шийдэх энэ бүрэн эрх зөрчигдсөн үү, энэ маргаантай байгаа энэ асуудлуудыг яаж шийдвэрлэх вэ гэдэг ийм зүйл дээр Засгийн газар дээр бид нар ажиллаж байсны хувьд энэ нэгэнтээ тараагдаад, хэвлэлт ч бас гарчихсан. Тэгээд ингээд эргэлзээ төрүүлээд ингээд хэлэлцэхгүй ингээд яваад байхаар өөрөө бас ийм асуудалтай.

Мөнхтулга гишүүнтэй би бас уулзаж ярилцсан. Мөнхтулга гишүүний хувьд бол бас түр хороо нь илүү том бүтцээр ажиллах нь зүйтэй болов уу гэдэг ийм зүйлийг ярьсан. Цаг хугацааны хувьд бас яагаад ингээд одоо өргөн баригдчихав эд нар гэдэг ийм бас асуудлууд яригдаж байгаа. Энэ бол 7 сараас эхлээд бид нар наадмын дараа бас уулзаж ярилцаад, нэгэнтээ ингээд бас олон нийтэд ярьчихсан, өргөн баригдах тогтоол нь орохоор болчихсон, тэгээд олон нийт бас их хүлээлттэй байгаа учраас үүнийг Улсын Их Хурлын түвшинд хэдүүлээ бас ярилцаад, энэ дүгнэлтийг гол нь энэ материалуудыг, дээрээс нь Баяр даргын эмхэтгэж өгсөн номыг ч гэсэн би

бас авсан. Гэхдээ энийг олон нийт сайн мэдэхгүй. Тэгэхээр энийг ингээд задлан шинжилгээ хийгээд, дэс дараалалтайгаар хүргэх нь зүйтэй юм шүү.

Төлөөлөл дээр бол ерөөсөө 1 их оролцсон зүйл байхгүй. Намуудын бүлгүүд өөр өөрсдийн ийм нэрсийг өгсөн байгаа гэдгийг хэлье. Хариулж дууслаа. Баярлалаа.

Р.Сэддорж: 1 минут байгаа. Уянга гишүүн.

Б.Уянга: 1 зүйлийг бас тодруулаад хэлэхийг хүслээ. Ер нь бол манай Монгол Улс төсвөө хэлэлцэж байхад дандаа зарлага талаа яриад, орлогоо нэмэгдүүлэх ёстой гээд л бүгд ярьж байгаа. Тэгээд ойрын хэдэн жилдээ л бол бид нар уул уурхайн салбарыг тэр дундаа хариуцлагатай уул уурхайг бол хөхиүлэн дэмжихээс өөр аргагүй байгаа. Уул уурхайн салбарын ер нь хариуцлага гэж юун дээр нь байдаг юм бэ гэхээр үр өгөөжийг л ярьж байгаа. Байгаль орчны үр өгөөж, нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр өгөөж гээд. Тэгээд зүгээр Өмнөговь аймгийн Цогтцэций сум болохоор яг хувь хүний хувьд манай өвөөгийн нутаг юм байгаа юм. Тэгэхээр энэ төсөл буюу энэ Ухаа худгийн төсөл хэрэгжихээс өмнө 2000 хүрэхгүй ч байлуу даа хүн амтай байж байгаад одоо 10 мянган хүн амтай болоход нэр, нийгмийн үр өгөөжийг маш сайн өгсөн ийм төсөв төсөл байдаг юм. Тэгээд магадгүй энэ түр хороогоор энэ агуулга нь илүү сайн яригдах болов уу. Яригдаасай гэж бол хүсэж байна. Сургуульд нь, цэцэрлэгт нь, орон сууцад нь, ажилчдадаа хүртээж байгаа үр өгөөжийг нь .../минут дуусав/

Р.Сэддорж: Оюун-Эрдэнэ гишүүн.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ том төслүүдтэй холбоотой, Оюутолгойтой ч холбоотой аль ч асуудал дээр ер нь бол миний хувьд дандаа л дэмжих байр суурьтай явж ирсэн. Өмнө нь гацсан төслүүдийг ч гэсэн хөдөлгөх, эргэлзээг нь тайлах, аль болохоор консенсуст ороод ингээд явах нь бол зүйтэй гэдэг ийм байр сууринаас хандаж ирсэн гэдгээ бас хэлье.

Гэхдээ энэ асуудлыг бидний хувьд бол нягтлаад, эргэлзээг тайлаад ингээд явах нь бол б Улсын Их Хурлын хувьд бас их тийм чухал зүйл юм. Энэ нь өөрөө уул уурхайн салбарыг илүү ойлгомжтой болоход орон нутгийн иргэд дэмждэг, хөрөнгө оруулагчдад бас илүү ойлгомжтой ийм орчин бүрдэж, өгөөж нь ч ойлгомжтой ийм байх асуудлыг ингээд бас ярилцах нь бол зүйтэй юм гэсэн ийм байр суурьтай байгаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Ухаа худгийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой Хянан шалгах түр хороо байгуулахыг бол дэмжиж байгаа. Тэгээд мэдээллээ ил тод нээлттэй хийе. Юу нь мэдэгдэхгүй ийм янз янзын хардалтуудыг зогсоосон нь зөв байх. 2 дугаарт нэг ийм асуудал үүсэх гээд байна. Энэ юу вэ гэхээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32.2 дээр Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хянан шалгах түр хороог байгуулахдаа шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, тухайн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана гээд ийм хуульчилчихсан.

Тэгээд Оюун-Эрдэнэ гишүүний гаргаж байгаа санал дээрээс харахаар яах вэ үндэслэл нь мэдэх эрхийг нь хангая гэж байгаа юм байна. Хүрээ хязгаар дээр нь

асуудал үүсээд байгаа юм. Энд Ухаа худаг гэхээд ... дугаартай Ухаа худаг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалтын үйл ажиллагаатай холбогдуулж гээд Ухаа худаг гэж нэрлэхээд бүгдийг нь бусдыг нь шалгая гээд байгаа юм. Хянан шалгах түр хороо нь. Тэгэхээр энэн дээр нэг асуудал үүсэх гээд байгаа юм.

1 дүгээрт хууль дээрээ хүрээ хязгаараа их тодорхой тусга гэхихсэн. Энэ хүрээ хязгаар нь тодорхойгүй байна.

2 дугаарт тодорхойгүй байснаараа ямар үр дүнд хүрэх гээд байна гэхээр эргээд манай Ардчилсан намынхан бас таны гаргасан шийдвэрүүдтэй холбоотой бас нэг хянан шалгах түр хороо байгуулъя гээд явж байдаг. Гэтэл таны энүүгээр болохоор би бүгдийг нь өөрөө шалгая гэдэг ийм юм яваад байдаг. Тэгээд та бол өөрийгөө шалгана гэж байхгүй л дээ. Тэгэхээр энийг Байнгын хорооны даргаа, яах ёстой юм бэ. Тодорхой болгож оруулж ирээд, тэгээд 1 мөр Ухаа худгаа шалгах гэж байгаа бол Ухаа худгийн хяналт шалгалтын сонсголыг нь хийгээд, тэгээд тантай холбоотой шийдвэрүүдийг нь манай Ардчилсан намынхан гаргаж ирж байгаа энэ Хянан шалгах түр хороогоо тусад нь байгуулаад ингээд явмаар байна. Энэ асуудлыг яах вэ.

Р.Сэддорж: Оюун-Эрдэнэ гишүүн хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Яах вэ, энэ гарын үсэг зурсан гишүүдийн хувьд бас энэ төслийг зөвхөн ганцааранг нь онцлох нь жоохон учир дутагдалтай юм гэдэг ийм өнцөг ярьсан юм. Тэгэхээр энэ дээр томъёоллын хувьд хүрээ хязгаарыг бусад төслүүдийг нь хасчхаж болно. Тэгээд бусад асуудлаа ярьдгаараа яриад, би ч гэсэн түүнийг бас дэмжиж байгаа. Одоо жишээлбэл хамтдаа ярилцсан асуудал нөгөө Гашуунсухайт-Ганцмодны холболттой холбоотой бас асуудлыг илүү тойрч ярих нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ төслийг бас явуулах гэж хамтарсан Засгийн газар байгуулж ажиллах нь зүйтэй гэж үзсэн. Энэ төсөл явсанд бас баяртай байгаа. Гэхдээ миний байр суурь бол бас нягтлаад, тэгээд болох зүйлийг нь болж байгаагаар нь яриад, олон нийтийн эргэлзээг нь тайлаад, болохгүй бол одоогийн Засгийн газар цуцлах саналаа Улсын Их Хуралд оруулаад цуцалчхаж болно. Энэ дээр миний хувьд зайлшгүй энэ төсөл хамгийн зөвөөр хийгдсэн. Энийг би заавал хамгаалах ёстой гэдэг тийм хатуу байр суурь бол байхгүй байгаа. Юутай ч Засгийн газар олон жил гацсан энэ төслүүдийг хийсэн нь чухал. Илүү сайн хувилбар байвал цуцлаад дахиад хийх нь бас эрх нь нээлттэй гэж бодож байгаа шүү.

Тийм учраас хэрвээ Байнгын хороонд тийм эрх байгаад яавал төлөөлж 33 гишүүний бас ярьж байгаагийн хувьд цар хүрээг Лодой гишүүнтэй яг адилхан байдлаар зохицуулалт хийвэл миний хувьд бол дэмжиж байна.

Р.Сэддорж: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль дээр 32.4 дээр тогтоолын төслийг холбогдох Байнгын хороо хэлэлцэж, түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, Үндсэн хуульд харшилсан эсэх талаар санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн байна. Тэгэхээр нэгдсэн хуралдаанд энэ асуудлыг шийднэ. Ингээд нам эвслийн бүлгээс ирсэн ... Лодойсамбуу гишүүн тодруулга.

Ч.Лодойсамбуу: Тодорхой тайлбарлаад өгье. Байнгын хороон дарга аа, одоо яана гэсэн үг юм. Тэгэхээр тогтоолын төсөл санаачилж байгаа тал бол миний гаргаж байгаа саналыг дэмжээд байна шүү дээ. Ухаа худгаа тусад нь шалгая гэж. Бид нар

бол бусад хэлэлцээрүүдийг нь бас шалгая гээд байгаа энэ өөрийнх нь гаргасан шийдвэртэй холбоотой юмнуудыг бас мэдээлэл авъя гээд байгаа. Энэ 2-ыг салгамаар байна гэж. Тэгэхээр хаана, яг яаж салгах боломжтой юм бэ гэдэг дээр тодорхой тайлбар мэдээлэл өгөөч.

Р.Сэддорж: Саяын хуулийн 32.5 дээр санаачлагч гишүүд санал нэгдэн зөвшөөрсөн бол түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг өөрчлөхөөр бол энэ хуулийн 32.5-д заасан үндэслэлээр Улсын Их Хурлын тогтоолоор өөрчилнө. Чуулган дээр л бүх асуудлаа шийднэ л гэсэн үг. Хэлэлцэж байх явцад хийгдэнэ шүү дээ. Оюун-Эрдэнэ гишүүн.

Л.Оюун-Эрдэнэ: Энийг би бас протоколд тэмдэглүүлээд үлдээчихье. Нэг үгээр хэлбэл Гашуунсухайт-Ганцмодтой холбоотой 2 улсын Засгийн газар тийм ээ, хамтдаа зураад, Улсын Их Хурал соёрхон баталсан энэ асуудлын баримт, гэрээ эд нар нууц гэж яваад байгаа. Энэ нууц юм юу ч байхгүй шүү. Зүгээр 2 улсын Засгийн газар бие биедээ хүндэтгэлтэй хандахын тулд гуравдагч этгээдэд танилцуулахдаа бие биеэсээ зөвшөөрөл авна л гэсэн юм байгаа. Тэгэхээр энийг Хятадын талаас зөвшөөрөл аваад, нээлттэй ярьж болно. Их Хурлын гишүүдэд ч гэсэн нээлттэй л тараагдсан ийм сэдэв. Тэгэхээрээ энэ сэдэвтэй холбоотой асуудал нэгэнтээ манай Засгийн газрын асуудал учраас сонирхлын зөрчилтэй гэж үзээд, энэ сэдэвтэй холбоотой асуудлыг орхино гэдгийг би протоколд оруулчихъя.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Нам эвслийн бүлгүүдээс ирсэн нэрсийг танилцуулъя.

Үндэсний эвслээс Улсын Их Хурлын гишүүн Ундраагийн нэрийг ирүүлсэн байна.

Улсын Их Хурал дахь Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Алтаншагай гишүүн, Ганхөлөг гишүүн, Оюун-Эрдэнэ гишүүн, Сайнзориг гишүүн, Сандаг-Очир гишүүн, Саранчулуун гишүүн, Эрдэнэбат гишүүдийн нэрсийг ирүүлсэн байна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл гишүүн, Баясгалан гишүүн, Эрдэнэбүрэн гишүүн, Мөнхбаясгалан гишүүн нарын нэрсийг ирүүлсэн. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд санал болгож буй гишүүд нь тус асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй болно гэж ирүүлсэн байна.

ХҮН намаас Улсын Их Хурлын гишүүн Энхнасангийн нэрийг ирүүлсэн байна.

Иргэний Зориг Ногоон намаас Улсын Их Хурлын гишүүн Батболдын нэрийг ирүүлсэн байна. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд санал болгож буй гишүүн нь тус асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй болно гэсэн ийм нэрсийг ирүүлсэн байна.

Түр хорооны бүрэлдэхүүний талаарх тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай”

Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дугаар хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан Тавантолгойн нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаан худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалтын үйл ажиллагаатай холбогдуулж хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг ашиглах, үйл ажиллагаа, олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, холбогдох баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх”-ээр тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай.

1/Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаар дугаартай “Ухаан худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг ашиглах үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах;

2/Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянан шалгах;

3/Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшигч хуулийн этгээдийн оруулсан хөрөнгө оруулалт, олборлосон нүүрс, үйл ажиллагаа, мөнгөн урсгалд дүн шинжилгээ хийх;

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Олонхыг төлөөлөн

Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Алтаншагай, Ганхөлөг, Оюун-Эрдэнэ, Сайнзориг, Сандаг-Очир, Саранчулуун, Эрдэнэбат нарын гишүүд;

Цөөнхийг төлөөлөн

Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл, Баясгалан, Батболд, Мөнхбаясгалан, Ундраа, Энхнасан, Эрдэнэбүрэн нарын гишүүд;

4.Тусгай шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлж, тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасан хугацаанд Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг хянан шалгах түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийг танилцууллаа. Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооны хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Буяагийн Тулга гишүүн танилцуулна.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаан идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

17.07 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ